



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 398

Улаанбаатар
хот

Тогтоолын заалт, хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хувийн № 16..

1. “Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох тухай” Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 75 дугаар тогтоолын 1 дэх заалтын болон 1 дүгээр хавсралтын гарчгийн “Засгийн газрын” гэснийг “Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын” гэж өөрчилсүгэй.

2. Мөн тогтоолын 1 дэх заалтын болон 4 дүгээр хавсралтын гарчгийн “Ерөнхийлөгчийн” гэсний дараа “болон Засгийн газрын” гэж нэмсүгэй.


3. Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний албан тушаалын “ТЗ-15” зэрэглэлийн 1 дүгээр шатлалын цалин “1090156” гэснийг “1554760” гэж, 2 дугаар шатлалын цалин “1161226” гэснийг “1654426” гэж, 3 дугаар шатлалын цалин “1232536” гэснийг “1755052” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолын 1 дэх заалтын “Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралт,” гэснийг, мөн тогтоолын 1 дүгээр хавсралтыг болон “Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох тухай” Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 75 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдон гарах зардлыг жил бүрийн батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

Хувийн № 16

6. Энэ тогтоолыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

А.АРИУНЗАЯА